НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН СОЁЛ УРЛАГ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН БОДЛОГО ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Т.БАЯРЗУЛЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр-Аймгийн ЗДТГ

Нэгжийн нэр-Нийгмийн бодлогын хэлтэс

**1.Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан батлагаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Нэг. Соёл, урлаг, залуучууд, аялал жуулчлалын чиглэлээр** | | | | | |
| 1 | Арга хэмжээ 1.1. Соёлын салбарын хүний нөөцийг хөгжүүлж, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх | 60 | 10 | 70 | |
| 2 | Арга хэмжээ 1.2. Соёлын сэргэлт-2025 арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх | 60 | 10 | 70 | |
| 3 | Арга хэмжээ 1.3 Ард иргэдэд хүргэх соёл, урлагийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна. | 60 | 10 | 70 | |
| 4 | Арга хэмжээ 1.4 Аялал жуулчлалын бодлогын баримт бичигт тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлж, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хүрээлэн буй орчны менежмент, стандартад нийцүүлэн хөгжүүлнэ. | 60 | 10 | 70 | |
| 5 | Арга хэмжээ 1.5 Алтайн нуруу, бүсийн байгаль, бүсийн байгаль, газарзүйн онцлогт түшиглэсэн адал явдал, тусгай сонирхлын, хил орчмын болон хил дамнасан аяллыг хөгжүүлнэ. | 30 | 5 | 35 | |
| 6 | Арга хэмжээ 1.6 Нийгмийн харилцааны соёлыг төлөвшүүлэх цогц ажлууд, нөлөөллийн аян зохион байгуулах | 60 | 10 | 70 | |
| 7 | Арга хэмжээ 1.7<br>Төрөөс залуучуудын талаар баримталж буй бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангах, сурталчлах олон талт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулна. | 60 | 10 | 70 | |
| 8 | Арга хэмжээ 1.8.<br>35 дахь удаагийн номын баярыг зохион байгуулна. | 60 | 10 | 70 | |
| 9 | Арга хэмжээ 1.9. "Туульсын | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Хаан Жангар" өв соёлын наадмыг зохион байгуулах | 60 | 10 | 70 | |
| 10 | Арга хэмжээ 1.10.<br>Аймгийн Засаг даргын салбарын сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг тайлагнаж, сумын Засаг дарга нартай байгуулсан гэрээний салбарын зорилтуудын хэрэгжилтэд хяналт тавина. | 60 | 10 | 70 | |
| Зорилт 4. "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах"-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт | | | | | |
| 1 | Арга хэмжээ 4.1<br>Төрийн албан хаагчийн ёс зүйг баримтлан ажиллаж удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, хариутай бичгийг хугацаанд нь шийдвэрлүүлнэ. | 60 | 10 | 70 | |
| 2 | Арга хэмжээ 4.2 Бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг хугацаанд нь гаргаж яам, холбогдох хэлтсүүдэд хүргэх | 60 | 10 | 70 | |
| 3 | Арга хэмжээ 4.3 Иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж, хариуцсан асуудлын хүрээнд ирсэн өргөдөл, гомдлыг хугацаанд нь судлаж хариуц мэдэгдэнэ. | 58 | 8 | 66 | |
| 4 | Арга хэмжээ 4.4<br>Хэлтэст ирсэн албан бичгийг бүртгэж, холбогдох мэргэжилтэнд шилжүүлэн шийдвэрлүүлнэ. | 60 | 10 | 70 | |
| Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт | | | | | |
| 1. | "Угийн бичиг – Удмын хэлхээ 2024–2028" хөдөлгөөнийг зохион байгуулахад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэв. | 60 | 10 | 70 | |
| 2. | Монгол Улсын иргэний андгай өргөх ёслолыг Засаг даргын ивээл дор зохион байгуулах | 60 | 10 | 70 | |
| 3. | "Торгоны зам" авторалли зохион байгуулах | 60 | 10 | 70 | |
| | Дундаж оноо | | | 63,5 | |

2.Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2р | 3 | 4 |
| 1 | Арга хэмжээ 1. Хариуцсан салбарын чиглэлээр сургалтад хамрагдана. | 100 | 15 | |
| 2 | Арга хэмжээ 2. Хариуцсан салбарын байгууллагыг мэргэжил, арга зүйгээр | 100 | 15 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хангаж ажлын байрандаа суралцана. | 100 | 15 | |
| Дундаж оноо | | | 15 | |

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

| д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1 | Хандлага,ёс зүй | 5 | |
| 2 | Дүн шинжилгээ хийх | 7 | |
| 3 | Асуудал шийдвэрлэх | 7 | |
| 4 | Хариуцлагатай байдал | 7 | |
| 5 | Ажлын цаг ашиглалт | 5 | |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | | |
| 6 | Мэргэжлийн ур чадвар 1. | | |
| 7 | | | |
| 8 | | | |
| Дундаж оноо | | 6,2 | |

4.Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (хамт олны үнэлгээ)

| д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7 |
| 2. | Багаар ажиллах | 7 |
| 3. | Харилцаа | 7 |
| Дундаж оноо | | 7 |

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

| д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт орно) | 63,5 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 15 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ) | 6,2 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ) | 7 |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт | |
| Нийт оноо | | 91,7 |

**Үнэлгээ өгсөн:** **Нэгжийн дарга**

НБХ-ийн дарга ............................ /Ж.Амгаланбаатар/

2025/12/08.

**Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:** **Төрийн жинхэнэ албан хаагч:**

НБХ-ийн мэргэжилтэн ............................ /Т.Баярзул/

............................

**Үнэлгээг хянасан:**

***Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:***

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.БУЯНХИШИГ

*2025 оны 12 сарын 11 өдөр*

***Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:***

ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Ч.НЯНДАГ

*2025 оны 12 сарын 11 өдөр*

***Үнэлгээг баталгаажуулсан: Төсвийн шууд захирагч***

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Ш.ЭРДЭНЭБАТ

*2025 оны 12 сарын 15 өдөр*

**НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН СОЁЛ УРЛАГ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН БОДЛОГО ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Т.БАЯРЗУЛЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин /биелэлт/ | Эхэлсэн, дууссан хугацаа | Хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Нэг. Соёл, урлаг, залуучууд, аялал жуулчлалын чиглэлээр | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 1.1. Соёлын салбарын хүний нөөцийг хөгжүүлж, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх | Дэмжлэг үзүүлсэн албан хаагчийн тоо | 10 | - | Аймгийн 19 соёлын төв, ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын хөгжмийн багш, техникийн ажилчдыг чадавхжуулах сургалтыг 02 дугаар сарын 08-ны өдөр “Саунд мюзик студи”-тэй хамтран 66 албан хаагчийг хамруулан зохион байгууллаа.<br>Эх бэлтгэл, видео эвлүүлгийн сургалтыг “Атга чихэр” студитэй хамтран 2025 оны 03 дугаар сарын 20, 21-ний өдрүүдэд зохион байгуулж, соёлын салбарын нийт 18 албан хаагч хамрагдаж байгууллагынхаа үйл ажиллагаа сурталчлан таниулах олон нийтэд түгээх эх бэлтгэн, видео эвлүүлэг хийх чадварыг эзэмшлээ.<br>Аймгийн Засаг даргын Тамгын газар Ардын дуу бүжгийн Алтай чуулгын 3 уран бүтээлчийн шинэ уран бүтээлийн зардалд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 14,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ. | 1-12 | Хэрэг жсэн |
| 2 | Арга хэмжээ 1.2. Соёлын сэргэлт-2025 арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх | Арга хэмжээний тоо | - | - | Монголчуудын эрт дээр үеэс уламжлал болгон хэрэглэж ирсэн аяганы уутны хэрэглээг сэргээх, хүн бүр өв соёлоо эрхэмлэн, байгальд ээлтэй эрүүл амьдралын хэв маягт суралцах зорилготой “Аяганы соёл” аяныг 2024 оноос эхлэн хэрэгжүүлж, одоогийн байдлаар нөлөөллийн арга хэмжээ 20, аймаг болон улсын хэмжээний үзэсгэлэн 3-ыг зохион байгуулж, 20000 гаруй хүн хамрагдсан бөгөөд нийт хүн амын 20 хувь нь аяганы соёл аяныг дэмжиж оролцлоо. “Аяганы соёл” үзэсгэлэн худалдааг аймгийн Жангар музейн үзэсгэлэнгийн танхимд зохион байгуулж 10 сум, 1 тосгоны нийт 22 дэсийн 200 ширхэг эд зүйл дэлгэдэж насанд хүрэгч 272, хүүхэд 72 нийт 344 үзэгч үзэж сонирхлоо. Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Гэр” үзэсгэлэнгийн үеэр аяганы соёл үзэсгэлэн гаргаж 12800 үзэгч үүнээс насанд хүрэгч 6150, хүүхэд 6500, жуулчин 124, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 26 үзэж сонирхсон байна. Үндэсний баяр наадам, сар шинийн баяртай уялдуулан уриалга контентуудыг бэлтгэн ард | 1-12 | Хэрэг жсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | иргэдэд хүргэснээр цагаан сараар айлд зочлохдоо өөрийн аягатай зочилж байгаа хүмүүс олон байгаа нь тус аяны үр дүн юм. Соёл урлагийн салбарын албан хаагчдын эрүүл мэнд, идэвхтэй хөдөлгөөнийг дэмжиж, салбар дундын уялдааг хангах, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор "Спортын III наадам"-ыг 01 дүгээр сарын 09-ний өдөр спортын 3 төрлөөр амжилттай зохион байгуулж, 150 гаруй албан хаагч хамрагдлаа. Тус тэмцээнийг зохион байгуулахад улсын төсвөөс 2.5 сая төгрөгийг зарцуулаа. | | |
| 3 | Арга хэмжээ 1.3 Ард иргэдэд хүргэх соёл, урлагийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна. | Иргэдийн тоо | - | - | Ардын дуу бүжгийн Алтай чуулгын уран бүтээлчид алтай ятга хөгжмийг цэнгүүлэх "Чөргөөлгөн цагаан аялгуу", аймгийн баяр наадамд зориулсан "Алтан говийн сүмбэр Алтай мину-2" шинэ уран бүтээлийн тоглолт болон Улаанбаатар хотноо "Дурсамж дүүрэн он жилүүд", 17 сум, 2 тосгонд "Шилдэг уран бүтээл"-ийн тоглолтыг тус тус зохион байгуулж 7550 үзэгч үзэж сонирхлоо. Ардын дуу бүжгийн Алтай чуулгын 60 жилийн ойн тоглолтын ерөнхий найруулагчаар "Бий биелгээ өвлүүлэх холбоо" ТББ тэргүүн, Хөдөлмөрийн баатар, Төрийн соёрхолт, Урлагийн гавьяат зүтгэлтэн С.Сүхбаатар, хөгжмийн зохиолчоор Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт, СТА Б.Бямбабаяр, хөгжмийн зохиолч, Урлагийн гавьяат зүтгэлтэн, хормейстрээр алтан гадас одонт хөгжмийн зохиолч С.Тараа, бүжгийн багш найруулагчаар СТА Д.Дашдаваа нартай хамтран ажиллахаар 180.0 сая төгрөгийн гэрээ байгууллаа. | 1-12 | Хэрэг жсэн |
| 4 | Арга хэмжээ 1.4 Аялал жуулчлалын бодлогын баримт бичигт тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлж, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хүрээлэн буй орчны менежмент, стандартад нийцүүлэн хөгжүүлнэ. | Үйлчилгээний тоо | - | - | "Ээж хайрхан уул-эхийн элбэрэл" аялал энергийн төвд хүслээ даатгах, сакура (буйлс) цэцэглэхийг үзэх зорилтот аяллыг 2022 оноос хойш 4 дэх жилдээ зохион байгуулж 3000 гариу жуулчин хамрагдлаа.<br>"Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийн хүрээнд иргэд, олон нийтийн амралт, эрүүл мэнд, идэвхитэй хөдөлгөөнийг дэмжих зорилгоор "Мөсний баяр-2025" арга хэмжээг төрийн байгууллагуудтай хамтран 01 дүгээр сарын 18-ны өдөр Есөнбулаг сумд 70 гаруй төрийн байгууллагуудын 110 гаруй албан хаагчид болон 15 сумдад зохион байгуулж нийт 1780 төрийн албан хаагчид хамрагдлаа.<br>Олон улсын "Тахь" групптэй хамтран Говийн их дархан цаазат газрын "Б" хэсгийн ховор, нэн ховор амьтад болон өвөрмөц байгалийг түшиглэсэн 5 удаагийн аялал зохион байгуулж 35 жуулчин хамрагдлаа.<br>Аялал жуулчлалын салбарын нэгдсэн "Боломж ба шийдэл" анхдугаар зөвлөгөөн 05 дугаар 27-ны өдөр зохион байгуулагдаж 115 төлөөлөгч оролцлоо<br>Монгол Улс, Оросын Холбооны Улсын нутаг дэвсгэрийг дамнан зохион байгуулагддаг "Торгоны зам" олон улсын авто ралли уралдаан 07 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд зохион байгуулагдаж тус уралдаанд 12 орны нийт 843 тамирчин, оролцогчдын 306 авто машин техник хэрэгсэл | 1-12 | Хэрэг жсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хамрагдаж Жаргалан, Баян-Уул, Хөхморьт сумдын нутгаар дайран өнгөрснөөр зорилтот авто аялалыг олон улсад сурталчлан таниулсан үйл ажиллагаа боллоо.<br>Говь-Алтай 80+ эрүүл мэндийн хөтөлбөрийн хүрээнд "Алтай хот-Эрээн нуур" хүртэлх 150 км холын зайн явган алхалтын "Нүүдлийн аялал зуслан" арга хэмжээг эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран эм эмнэлгийн хэрэгслийн анхан шатны тусламжаар дэмжлэг үзүүлж, зохион байгуулсан ба 43 хүн хамрагдлаа.<br>Жангар тууль хайлах арга хэмжээг 2025.12.22-ны өдөр Алтай хотод зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. | | |
| 5 | Арга хэмжээ 1.5 Алтайн нуруу, бүсийн байгаль, бүсийн байгаль, газарзүйн онцлогт түшиглэсэн адал явдал, тусгай сонирхлын, хил орчмын болон хил дамнасан аяллыг хөгжүүлнэ. | Үйлчилгээний тоо | - | - | Монгол төдийгүй дэлхийд ховордсон нэн ховор, ховор амьтдыг түшиглэсэн тусгай сонирхлын чиглэлээр Олон улсын тахь групптэй хамтран "Говийн их дархан цаазат газрын Б" хэсэгт 5 удаагийн аялал зохион байгууллаа. Говийн их дархан цаазат газрын "А", "Б", хэсэгт зорилтот аялал жуулчлалаар нийт 1500 орчим жуулчин ирсэн үзүүлэлттэй байна. | 1-12 | Хэрэг жсэн |
| 6 | Арга хэмжээ 1.6 Нийгмийн харилцааны соёлыг төлөвшүүлэх цогц ажлууд, нөлөөллийн аян зохион байгуулах | Нөлөөллийн аяны тоо | - | - | Иргэдэд соёлын боловсрол олгох 8 удаагийн сургалтад 510 иргэн хамрагдлаа. Соёлын орон зай, орчныг бүрдүүлэх соёлын үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэх, соёлын харилцаа, урлагийн бүтээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, нийгэмд эерэг нөлөө бүхий бүтээлч ажил, соёлыг олон нийтэд түгээн сурталчлах "Соёлын орон зай-Бидний орчин" бүтээлч аян уриатайгаар улсын хэмжээнд өрнөж 10 дугаар сарын 03-наас 11 дүгээр сарын 03-ны өдрүүдэд аймгийн хэмжээнд 1320 арга хэмжээ зохион байгуулж 12350 хүнийг хамруулаа. Цахим орчинд нийтэлсэн контент 215, пост 875, "Соёл түгээе" аяны таалагдсан мэдээний тоо /лайк/ 11250, хуваалцсан мэдээний тоо /шэйр/ 12109, аяны хандалтын тоо /үзэлт/ 12109 байна. Тайлант хугацаанд давхардсан тоогоор нийт 36424 иргэнийг соёлын боловсрол олгох арга хэмжээд хамрууллаа. Соёлын боловсролтой иргэдийн эзлэх хувь 31,9 байна. | 1-12 | Хэрэг жсэн |
| 7 | Арга хэмжээ 1.7 Төрөөс залуучуудын | Хамрагдсан иргэдийн тоо | 2000 | 3000 | Залуучуудын гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүй, эрүүл мэнд, цус ойртолт ба уггийн бичиг хөтлөхийн ач холбогдол, үнэт зүйл амьдрах ухааны мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх, тэдний нийгмийн идэвхтэй оролцоог дэмжиж, хүн амын удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах, зэргэлдээх аймгуудын залуусыг өөр | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | талаар баримталж буй бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангах, сурталчлах олон талт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулна. | | | | хоорондоо танилцан, найзалж нөхөрлөх, харилцаа тогтоох боломжийг бүрдүүлэх зорилгоор "Жангар фестиваль-IV" залуучуудын нэгдсэн арга хэмжээг 2025 оны 07 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгууллаа. 2 өдрийн хөтөлбөрт арга хэмжээнд нийт 1200 залуу хамрагдлаа.<br>“Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-ийн хүрээнд 2025 оны элсэлтийн шалгалтын дүнгээр 650-800 оноо авч, их дээд сургуульд элсэн орсон 107 оюутанд нийт 316,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ. | | |
| 8 | Арга хэмжээ 1.8. 35 дахь удаагийн номын баярыг зохион байгуулна. | Арга хэмжээ | 2 | 11 | Монгол үндэсний бахархал, өв соёлоо түгээн дэлгэрүүлэх, хамгаалах, соёлын дархлааг дэмжих, уламжлалт дээл, хувцсыг өдөр тутамдаа өмсөж хэвших зорилгоор сар бүрийн эхний ажлын өдрийг “Үндэсний хувцасны өдөр” болгох тухай аймгийн Засаг даргын захирамж гарч, захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Аймгийн Засаг даргын 2025 оны А/69 дүгээр захирамжаар Монгол хэлний тухай хуулийн хэм хэмжээг мөрдүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Хэлний бодлогын орон тооны бус салбар зөвлөл шинэчлэн байгуулагдаж ажлын хэсгийг хуралдуулж 2025 оны төлөвлөгөөг хэлэлцэн баталлаа.<br>“Үндэсний бичиг, соёл-номын өдрүүд-2025” хаврын номын баярын арга хэмжээг зохион байгуулахад аймгийн Хэлний бодлогын салбар зөвлөлөөс 3,3 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ.<br>Мөн аймгийн нийт төрийн албан хаагчдад үндэсний бичгийн гарын авлага 1000ш номыг ОНТ-өөс 10,0 сая төгрөг зарцуулан худалдан авч түгээлээ. Үндэсний хэл, бичиг үсгээ эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх зорилгоор 2021 оноос эхлэн аймгийн төр, хувийн хэвшлийн бүх байгууллагууд үндэсний бичгийн стандарт болон гэрэлтдэг хаягтай болж, албан өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын энгэрийн тэмдэг, үнэмлэх, нэрийн хуудас зэргийг кирилл болон үндэсний бичгээр бичиж, бүх шатны Засаг дарга нар болон байгууллагын дарга, эрхлэгч нар айлтгал, мэндчилгээ, баярт мэдээг цахим орчинд үндэсний бичгээр бичиж нийтэлж, төрийн болон төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагууд албан хэргээ хос бичгээр хөтлөн явуулж хэвшлээ. | 1-12 | Хэрэг жсэн |
| 9 | Арга хэмжээ 1.9. “Туульсын Хаан Жангар” өв соёлын наадмыг | Арга хэмжээ | 1 | 1 | Орон нутгийн онцлог бүхий соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Туульсын хаан Жангар-2025” өв соёлын наадмыг жил бүрийн 12 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулж хэвшээд байна. | 1-12 | Хэрэг жсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулах | | | | Энэ жилийн наадамд ерөнхий боловсролын сургуулийн 680 сурагч , 80 бие биелээч, 240 товшуур хөгжимчид оролцуулан Алтай хотноо 4 дэх удаагаа зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.<br>Энэ удаагийн арга хэмжээнд ОНТ-өөс 106,0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.<br>Мөн наадмын хүрээнд өв соёлын үзэсгэлэн зохион байгуулагдах бөгөөд орон нутгийн соёлын брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нийт 20 гаруй иргэн, хуулийн этгээд оролцохоор бүртгүүлээд байна. | | |
| 10 | Арга хэмжээ 1.10. Аймгийн Засаг даргын салбарын сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг тайлагнаж, сумын Засаг дарга нартай байгуулсан гэрээний салбарын зорилтуудын хэрэгжилтэд хяналт тавина. | Хэрэгжилт хангагдсан байна. | - | - | Монгол улсын засгийн газрын гишүүн соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, аймгийн засаг даргатай төрийн зарим чиг үүргийг 2025 онд төлөөлөн гүйцэтгүүлэх гэрээний хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэн 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдөр хүргүүллээ. Хэрэгжилтийн хувь 97,8 хувьтай байна. | 1-12 | Хэрэг жсэн |
| Зорилт 2 "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 4.1 Төрийн албан хаагчийн ёс зүйг баримтлан ажиллаж удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, хариутай бичгийг хугацаанд нь | Хугацаанд нь биелүүлсэн ажлын тоо | - | - | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлж нийт 53 захирамж гаргаж, хэрэгжүүлж ажиллалаа. Яам, бусад байгууллагаас ирсэн 155 бичгийг бүртгэн хариуцсан мэргэжилтнүүдэд шилжүүлж хугацаанд нь шийдвэрлэж хүргүүллээ. Иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж, хэлтэст ирсэн 34 өргөдөл, гомдлыг хугацаанд нь шийдвэрлэж, албан бичгээр хариуг өглөө. | 1-12 | Хэрэг жсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шийдвэрлүүлнэ. | | | | | | |
| 2. | Арга хэмжээ 4.2 Бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг хугацаанд нь гаргаж яам, холбогдох хэлтсүүдэд хүргэх | Бодлогын баримт бичиг, шийдвэрийн тоо | - | - | Монгол улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичиг, Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлт, аймгийн Засаг даргын захирамж, албан даалгавар, салбарын сайдтай байгуулсан гэрээний биелэлтийг цагалбарын дагуу гарган хугацаанд нь өгч ажиллалаа. | 1-12 | Хэрэг жсэн |
| 3 | Арга хэмжээ 4.3 Иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж, хариуцсан асуудлын хүрээнд ирсэн өргөдөл, гомдлыг хугацаанд нь судлаж хариуц мэдэгдэнэ. | Хугацаанд нь шийдвэрлэсэн өргөдлийн тоо | - | - | Иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж, хэлтэст ирсэн 34 өргөдөл, гомдлыг хугацаанд нь шийдвэрлэж, албан бичгээр хариуг өглөө. | 1-12 | Хэрэг жсэн |
| 4 | Арга хэмжээ 4.4 Хэлтэст ирсэн албан бичгийг бүртгэж, холбогдох мэргэжилтэнд шилжүүлэн шийдвэрлүүлнэ. | Бичгийн тоо | - | - | Яам, бусад байгууллагаас ирсэн 155 бичгийг бүртгэн хариуцсан мэргэжилтнүүдэд шилжүүлж хугацаанд нь шийдвэрлэж хүргүүллээ. | 1-12 | Хэрэг жсэн |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээн)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | “Угийн бичиг – Удмын хэлхээ 2024–2028” хөдөлгөөнийг зохион байгуулахад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэв. | Хэрэгжилт хангагдсан байна. | - | - | “Угийн бичиг – Удмын хэлхээ 2024–2028” хөдөлгөөний хүрээнд Цогт, Хөхморьт, Баян-Уул, Дэлгэр сумдад “Угийн бичгийн булан”, Чандмань, Бигэр сумдад угийн бичгийн сургалт, мэдээллийн танхимыг шинээр тохижуулан ашиглалтад оруулсан бөгөөд иргэд угийн бичиг хөтлөх мэдлэг, арга зүйг авч, нийт 210 хүн үзэж сонирхлоо. | 1-12 | Хэрэгжсэн |
| 2 | Монгол Улсын иргэний андгай өргөх ёслолыг Засаг даргын ивээл дор зохион байгуулах | Хэрэгжилт хангагдсан байна. | - | - | Өсвөр үе, залуучуудыг түүх, соёлоо дээдэлсэн, эх оронч үзэлтэй, үүрэг хариуцлагаа ухамсарласан иргэн болгон төлөвшүүлэх зорилгоор 16 нас хүрч буй сурагчдад иргэний үнэмлэх, батламж гардуулах “Монгол Улсын иргэний андгай өргөх ёслол”-ын үйл ажиллагааг 11 дүгээр сарын 27-ны өдөр аймгийн Засаг дарга Г.Чинбатын ивээл дор зохион байгууллаа. Нийт 203 сурагч андгай өргөж иргэний үнэмлэхээ гардан авлаа.<br><br>Энэ үеэр Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх асан, “Бяцхан туслагч” номын зохиогч Н.Лхагвадорж ахлах ангийн сурагчдад мэргэжил сонголтын зөвлөгөө болон Англи хэлний сургалт зохион байгуулж, номоо бэлэглэн сурагчдын хэлний боловсролд үнэтэй хөрөнгө оруулалт хийлээ. Тус арга хэмжээнд нийт 1092 сурагч хамрагдлаа. | 1-12 | Хэрэгжсэн |
| 3 | “Торгоны зам” авторалли зохион байгуулах | Хэрэгжилт хангагдсан байна. | - | - | Монгол Улс, Оросын Холбооны Улсын нутаг дэвсгэрийг дамнан зохион байгуулагддаг “Торгоны зам” олон улсын авто ралли уралдаан 07 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд зохион байгуулагдаж тус уралдаанд 12 орны нийт 843 тамирчин, оролцогчдын 306 авто машин техник хэрэгсэл хамрагдаж Жаргалан, Баян-Уул, Хөхморьт сумдын нутгаар дайран өнгөрснөөр зорилтот авто аялалыг олон улсад сурталчлан таниулсан үйл ажиллагаа боллоо. | 1-12 | Хэрэгжсэн |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин /биелэлт/ | Эхэлсэн, дууссан хугацаа | Хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Арга хэмжээ 1. Хариуцсан салбарын чиглэлээр сургалтад хамрагдана. | Сургалтын тоо | 2 | 2 | 1.Удирдлагын академийн төрийн албан хаагчийг мэргэжүүлэх дунд хугацааны давтан сургалтад хамрагдан төгслөө.<br>2.Эдийн засаг хөгжлийн яамны Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах 2 өдрийн сургалтад хамрагдлаа.<br>3.Ховд хотод зохион байгуулагдсан Төрийн албаны зөвлөлийн Төрийн албаны шинэтгэл сургалтад хамрагдлаа.<br>4. Хэлний бодлогын үндэсний зөвлөлөөс явуулсан 3 удаагийн цахим сургалтад хамрагдлаа. | 1-12 | Хэрэгжсэн |
| 2 | Арга хэмжээ 2. Хариуцсан салбарын байгууллагыг мэргэжил, арга зүйгээр хангаж ажлын байрандаа суралцана. | Хамтран ажилласан байгууллагын тоо | 3 | 3 | Соёл урлаг, аялал жуулчлалын салбарын соёлын төвүүд болон мэргэжлийн урлагийн байгууллага, агентлаг нийлсэн 20 байгууллагуудтай хамтран ажиллаж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллалаа. | 1-12 | Хэрэгжсэн |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН СОЁЛ УРЛАГ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН БОДЛОГО ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ................................ Т.БАЯРЗУЛ /2025.12.04/